

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(2009 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	40.4	2.02
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	29.0/116.2	5.0
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	81.3	4.06
Үнэлгээний дундаж оноо				<b>3.69</b>
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	88.9	4.44
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	85.3	4.26
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100.0	5.0
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	25.4/101.8	5.0
Үнэлгээний дундаж оноо				<b>4.67</b>
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	90.5	4.52
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	92.0	4.6
Үнэлгээний дундаж оноо				<b>4.56</b>
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	99.9	4.99
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100	5.0
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	98.5	4.92
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	98.0	4.9
Үнэлгээний дундаж оноо				<b>4.95</b>
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	95.8	4.79
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	76.1	3.80
Үнэлгээний дундаж оноо				<b>4.29</b>
<b>Ерөнхий үнэлгээ</b>			<b>89.7</b>	<b>4.48</b>

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ

### ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

#### ХИЙСЭН ТАЙЛАН

Засаглалын эхний жил 2009 оныг Монгол Улсын Засгийн газар “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг дарга, Тамгын газар “Үйлдвэрлэлийн хүрээг өргөтгөж, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн иргэдийнхээ амьжиргааг сайжруулахад бодитой нөлөө үзүүлэх” зорилт тавьж уул зорилтоо хэрэгжүүлэх үүднээс аймгийнхаа нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын ажлын жигд ажиллагааг хангахад хөрөнгө санхүү, хүн хүч, материал, техник тоног төхөөрөмжийн нөөцөө бүрэн дайчилж чиглүүлэн ажилласнаар зохих үр дүнд хүрчээ.

#### Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

##### 1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт.

2009 онд Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан 66 заалтыг хяналтад авч ажиллалаа. Эдгээр заалтууд нь аймгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдтэй илүүтэй тохирч байсан юм.

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх ажлын явцад хяналт шинжилгээ хийж үзэхэд дараах анхаарвал зохих асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Уг баримт бичиг нь урт хугацааны турш хэрэгжих бодлогын баримт учраас хувь тавихад хүндрэлтэй байсан тул бид тухайн оны түвшинд хийсэн ажлынхаа гүйцэтгэлийн ерөнхий зорилт, хэрэгжих хугацаатай нь аль болох уялдуулж хувь тавихыг зорилоо.

2. Зарим хүрэхэд хэцүү, хөрөнгө мөнгө шаардсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа бодит нөхцөл байдал байгаа тул энэхүү зорилтыг хэрэгжүүлэх талаар хэрхэн ажилласан, ямар санаачлага гаргасныг үзэж тодорхой хувийн гүйцэтгэлийг тавилаа.

3. Аймгийн засаг даргын тамгын газар, бусад агентлаг албадын зүгээс гаргаж байгаа биелэлтүүдийг аль болох товч тодорхой байлгахыг зорьж ажиллалаа.

Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс харвал аймгийн засаг даргын тамгын газар нь дээрх хяналтанд авсан заалтуудыг хэрэгжүүлэх талаар нэлээдгүй ажлыг зохион байгуулсан харагдаж байгаа ба өндөр оноо бүхий гүйцэтгэлүүдээс гадна зарим онцлог ажлуудын эхлэл харагдаж байна. Тухайлбал: Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах зорилтын хүрээнд хийгдсэн Баруун-Урт сумын “Эсрэг осмус”-ын аргаар ус цэнгэгжүүлэх төхөөрөмж, Түмэнцогт сумын бактерийн аргаар цэвэрлэх байгууламж зэрэг дэвшилтэт технологи, амьтан ургамлын нөөцийг хамгаалах зорилтын хүрээнд авсан арга хэмжээний дүнд тус аймагт агнуурын ач холбогдолтой амьтадын тоо толгой нэлээдгүй хэмжээгээр өссөн, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд төрөөс олгож байгаа ЖДҮ-ийн зээлийг хугацаанд нь бүрэн олгож, үйлдвэр эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллаж байгаа зэрэг эерэг олон өөрчлөлтүүд, аялал жуулчлал тэр дундаа хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хийгдэж байгаа цогц бодлого, бүтээн байгуулалтын ажлууд, мал сүргийг эрүүлжүүлэх, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилтын хүрээнд гүн хөлдөөсөн үрээр хийж буй зохиомол хээлтүүлэг, хүн амд урлаг соёлоор үйлчилж байгаа бодит ажлуудыг дурьдаж болох юм.

Түүнчлэн Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажил, малын хүчит тэжээл бэлтгэх, авто замын салбарт дэвшилтэд технологи нэвтэрүүлэх зэрэг зорилтуудын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь ч харагдаж байна. Энэ нь тухайн ажлын явцад хөрөнгө мөнгөний хомсдол нөлөөлсөнтэй холбоотой гэж үзэхээр байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын гүйцэтгэлийг дүгнэхэд зарим зохион байгуулалтын чанартай ажлуудын гүйцэтгэл харьцангуй өндөр, хөрөнгө шаардсан ажлуудын гүйцэтгэл харьцангуй доогуур дүгнэгдлээ. Ерөнхий гүйцэтгэлийн хувь 40,4 хувьтай байна.

Цаашид хэрэгжилт удаан байгаа гүйцэтгэлүүдэд илүүтэй анхаарч, явцад нь хяналт шинжилгээ үнэлгээ хийх, заавар зөвлөмж өгөх замаар хэрэгжилтийг хангах боломжтой гэж үзэж байна.

## 1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

Эрүүл мэнд:

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд дэд хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллаж

шаардлагатай хөрөнгийг орон нутгийн боломжинд тулгуурлан шийдэж ирлээ. Үүний үр дүнд хүн амын нас баралт 11,1 хувиар буурч, дундаж наслалт нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих зорилгоор эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах эмнэлгүүдийн сонгон шалгаруулалт явуулж 3 эмнэлгийг шалгаруулаа. Мөн хувийн хэвшлийн ортой эмнэлэг болон эмийн сангуудад даатгалын сангаас нийт 84.2 сая төгрөгийг хуваарилж зарцуулалтанд хяналт тавьж ажиллаж байна.

Ихэнх эмнэлэг стандарт шаардлага хангаж байгаа ба шаардлага хангахгүй 2 сумын эмнэлгийн барилгыг "Эрүүл мэнд -3" хөтөлбөрийн хүрээнд хөрөнгийг шийдвэрлүүлээд байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт амбулаторийн үйлчилгээний тоноглогдсон 2 автомашинтай болсоноор явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэж, 8 сумын эмнэлгийг шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангаж, 2 өрхийн эмнэлгийн автомашины асуудлыг шийдвэрлэлээ.

Сумын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулан, 7 эмнэлэгийг өөрийн эзэмшлийн худагтай болголоо.

Багийн бага эмч хүрэлцээгүй 3 суманд 6 эмчийг бэлтгэж, 6 эмчийг унаажуулан, 4 ажлын байрыг тохижуулж засварлан, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авлаа.

"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" дэд хөтөлбөрийн дагуу сүүлийн 3 жилийн байдалд дүгнэлт хийж, өвчлөлийг илрүүлэх, эмчлэх үзлэг, шинжилгээнд шаардагдах 4.7 сая төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргуулан хийж, илэрсэн өвчлөлийг эрүүлжүүлэх арга хэмжээг авсан ба хамрагдвал зохих насны хүн амын 55 хувь нь хамрагдлаа.

БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сургалтаар 23 лаборант бэлтгээд байна.

Эдгээр арга хэмжээний дүнд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 18,1 хувиар, 0-5 насны хүүхдийнх 0,3 пунктээр буурч улс, аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Мөн

халдварт өвчний гаралт өмнөх оноос буурчээ. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олноор хөдөөгийн 5 сумын эмнэлэг шалгарч I-III зэргийн гэрчилгээ авчээ.

Хөдөөгийн сумын болон өрхийн эмнэлгүүдийг Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч 4-5 хүн 2-3 эмнэлгийг хариуцан мэргэжил, арга зүйн зөвөлгөө өгч хамтарч ажиллаж байгаа нь шинэлэг ажил болжээ. Мөн ЭМШУИС-тай хамтарч багш шавийн эрдмийн уулзалт хийж, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг төлөвлөх аргачлал ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдвээр сургалт зохион байгуулж нийт 300 шахам эмч, ажилтнууд оролцож “Багц цаг”-аа 100 хувь биелүүлжээ.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нийтийг хамарсан арга хэмжээг 48 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 498 байгууллага, 3526 хүн хамруулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин нэмэгдсэн байна. Баруун-Урт сумын төвд "Биеийн тамир, спортын ордон " барих зураг төсвийг гүйцэтгүүлэн, хөрөнгийг 2010 оны төсөвт тусгуулах болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан:

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хүрээнд сумд баг бүртээ гэр цэцэрлэг ажиллуулж хамрагдалт 73.3 хувьд хүрэв. Цэцэрлэгийн хоолны зардалд 323.4 сая төгрөг, СӨБ-д 1.7 орчим тэрбум төгрөг зарцуулсан байна. Орон нутгийн төсвийн болон төслийн хөрөнгөөр 3 сумын 4 цэцэрлэгийн барилгыг засварлалаа.

Бага боловсролын хамран сургалт аймгийн дүнгээр 95 хувьд хүрсэн.

Аймгийн сургууль, цэцэрлэгүүд мэргэжлийн багшаар бүрэн хангагдаж ихэнх сургуулиуд багшийн хөгжлийн танхим байгуулж, багш нарын өрөөгөө тохижуулан, мэргэшлээ дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл боломжийг нь бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна. Энэ онд давхардсан тоогоор төрөл бүрийн 1375 сургалтанд нийт 2023 багш, удирдах ажилтан хамрагдан, магистрийн эчнээ сургалтанд ЕБС, СӨБ-ын 42 багш, удирдах ажилтан, докторантурт 1 хүн ажилттай суралцаж байна.

Бичиг үсгийн боловсрол олгох, дээшлүүлэх хүмүүсийн нэрчилсэн судалгааг гарган 105 хүнийг хамруулж бичиг үсэгт тайлагдсан хүний хувийн жин 98,91 хувьд хүрлээ.

Албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 460 хүүхэд буюу сургуулийн гадна байгаа хүүхдийн 81.9 хувийг хамрууллаа.

Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 10 суманд сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын дагуу өөрчилж тоног төхөөрөмжийн шинэчлэл хийжээ.

Тус онд 2 сургуулийн дотуур байрны барилгыг шинээр ашиглалтанд оруулж, 2-ыг засварласан байна.

Нэг сумын соёлын төвийн барилгыг шинээр ашиглалтанд оруулж, 2 сумын соёлын төвийн барилгад сантехникийн засвар шинэчлэл хийж, Сүхбаатар сумын музейн барилгад засвар хийгдсэн.

2009 онд 12 сумын 57 багийн 115 хүн номын сангийн явуулын үйлчилгээнд хамрагдсан байна.

Энэ онд ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагад нийт 2522 иргэнийг ажилд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 12 аж ахуйн, нэгж байгууллагад 27 иргэнийг хамруулж, нөхөн олговорт ХЭДСангаас 16.0 сая төгрөг зарцуулсан.

Аймгийн хэмжээнд 839 ажлын байр шинээр бий болгосон байна. Үүнд 756 буюу 90.1 хувь нь байнга, 83 буюу 9.9 хувь нь улирлын ажлын байраар хангагдсан байна. Мөн 214 иргэнд 292399.0 мянган төгрөгний зээл олгож 346 ажлын байр шинээр бий болсон.

ХХҮХ нь 15 нэр төрлийн сургалт явуулж 340 иргэн хамруулсаны 205 буюу 60.2 хувь нь ажлын байртай болсоны зэрэгцээ 875 иргэдэд зөвлөгөөн өгч, ХЭДСангаас 9744.7 мянган төгрөг олгоод байна. Үйлдвэр дээрхи сургалтанд 13 хүнийг хамруулсан байна.

Аймгийн МСҮТ-д энэ онд 221 хүүхэд шинээр элсэж нийт 626 хүүхэд суралцаж байна.

2008 оноос ХХҮХ-ийн бүх мэргэжилтнүүд нийгмийн ажилтныг бэлтгэх 3 удаагийн шаталсан сургалтанд хамрагдаж, мэргэжил, боловсролоо дээшлүүлсэн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр аймгийн ахмадын холбоо, ХБИ-н холбоо, Шинэ-Зуун гэр хороолол ТББ-тай хамтран олон ажил зохион байгуулсан нь үр дүнгээ өгчээ.

Аймгийн ядуу болон нэн ядуу өрхийн судалгааг гарган мэдээллийн санг бүрдүүлж, ядуурлаас гаргахаар сонгогдсон 265 өрхөөс ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамруулах, гэр олгох, орлогыг бодитой нэмэгдүүлэх замаар 212 өрхөд бодит дэмжлэг үзүүлээд байна.

2009-2010 оныг " Хүүхдийн амгалан тайван аюулгүй орчинг хангах жил болгон " АИТХ-аас зарлан хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд сургалтыг Их Британы хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулсан. Орон нутгийн телевизээр хүүхдийн " Найзуудаа наашаа сууцгаа " нэвтрүүлгийг 7 хоног бүрийн "Бямба" гаригт бэлтгэн явуулдаг болжээ.

Үйлдвэр, Хүнс, хөдөө аж ахуй:

Аймгийн хэмжээгээр хүн амын махны хэрэгцээг 100 хувь, төмс хүнсний ногооны хэрэгцээг 15 хувь, сүүний хэрэгцээг 30 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, гурилын хэрэгцээг 100 хувь импортоор /эх орны үйлдвэрээс/ хангаж байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээлд сүүний чиглэлийн үнээний ферм байгуулах 11 аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан 128.3 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Тус аймагт сүүлийн 10 гаруй жилд анх удаа 100 га-д тариа тарьж, "Ногоон хувьсгал" хөтөлбөрийн хүрээнд энэ онд төмс 47.1 га, хүнсний ногоо 24.2 га-д тариалалт хийж, төмс 369.2, хүнсний ногоо 183.1 тн-ыг, шинээр 13 хүлэмж авч тариалалт хийснээр аймгийн хэмжээгээр 6384 м2 бүхий 70 хүлэмжинд эрт ургацын ногоо тариалж, 11383 кг ургац хураан авсан.

"Атрын 3 дахь аян"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж атаршсан 28274 га талбайгаас 110 га талбайг эргэлтэнд оруулж шаардагдах үрийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээгээр авч улаанбуудай, тэжээлийн ургамлын тариалалт хийж улаан буудайн болон төмсний үр үржүүлж 2010 онд тариалах үрээ нөөцлөөд байна.

Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажил, үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах чиглэлээр мал сүргийг нутгийн шилдэг омог үүлдрийн малаар сайжруулсны дүнд аймгийн нийт малын 44.3 хувь цэвэр эрлийз, сайжирсан мал эзэлж байна. Сүү, махны чиглэлийн малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх явуулын цэг байгуулан 3 сумын тодорхой тооны малд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.

Тэмээн сүргийн тоо толгойн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор 2 сумдад тэмээчдийн зөвлөлгөөн сургалт зохион байгууллаа.

Арвин ашиг шимт цөм сүргийн малд ангилалт явуулж 29.7 мянган малыг хамруулсан ба үүний дүнд шилмэл I ангийн шаардлага хангасан 16.6 мянган хээлтэгч, хээлтүүлэгч малын ашиг шимийн гарц чанарыг тогтоож үржлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдээд байна. 2 суманд үржлийн аж ахуй шинээр байгуулагдлаа.

Баруун-Урт суманд эрчимжсэн аж ахуй эрхлэх газар нутгийг тогтоож сүүний фермер, цөм сүрэг бүрдүүлэх, махны үхэр, гахай үржүүлэх чиглэлээр 20 иргэн, аж ахуй нэгж 239.4 сая төгрөгний зээл аван үйл ажиллагаагаа явуулж байна. Бүсийн хэмжээнд загвар фермерийн аж ахуй байгуулах бодлого барин Түмэнцогт ОНӨҮ-ийн газрыг махны чиглэлийн үхэр өсгөн бордох загвар аж ахуй, Түмэнцогт сумыг загвар сум болгохоор сонгоод ажиллаж байна.

200 га талбайг бүрэн хашин хамгаалж, ургац нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээ авч ажилласнаар 220 тн өвс бэлтгэж га-ийн ургац ердийн хадлангийн талбайгаас 4-6 цн-ээр нэмэгдлээ. Хэрлэн голын ойролцоо 10 га талбайг хашиж, тэжээлийн нэг наст ургамал тариалж, 18.7 тн ногоон тэжээл (шимт) хураан авч нөөцөлсөн.

Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, сумдын мал эмнэлэг, үржлийн нэгжийг дэмжин ажиллахад анхаарч малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтыг хамрагдвал зохих малд бүрэн чанартай хийснээр сүүлийн 2 жил халдварт өвчин гараагүй бөгөөд бүх сумдын 35 мал эмнэлэг, үржлийн нэгжид стандартын үзлэг шалгалт хийснээс 15 МЭҮН 2-р зэргийн, 17 МЭҮН 3-р зэргийн, 3 МЭҮН хангалтгүй гэсэн дүнтэй шалгагдсан байна.

Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, усжуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд жил бүр өөрийн аймгийн нутаг дэвсгэр дэх оготны тархалтын судалгааг гаргаж, холбогдох газруудад хүргүүлэн мэрэгч амьтадтай тэмцэх ажлыг жилдээ 40.0 мя га-д явуулахаар боллоо. Бэлчээрт 24 өрмийн худаг уст цэг шинээр гаргаж,

инженерийн хийцтэй 1 худгийг сэргээн засварлалаа. Усны геофизикийн хайгуулын ажлыг явуулж, 50 уст цэг тогтоолгоод байна.

Иргэнд үнэгүй өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан мөрдөж 1040 иргэнд 94,4 га газрыг шинээр өмчлүүлснээр одоо аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 4421 иргэн гэр бүлийн хэрэгцээндээ 427.8 га газрыг хуулийн дагуу өмчлөөд байгаа нь нийт өрхийн 30.2 хувийг эзэлж байгаа.

40000 орон сууц хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 181 айлын 4 орон сууцны барилга баригдаж байгаа ба 28 айлын 2 орон сууцны барилгыг ашиглалтанд оруулжээ.

ӨМӨЗО Улиастай хошууны Хатавч боомтоос Монгол улсын Бичигт боомт хүртэл 110кВт өндөр хүчдэлийн шугамыг БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн Эрдэнэцагаан сумыг цахилгаан эрчим хүчээр хангаснаар аймгийн нийт сум эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдлоо.

Тайлант онд орон нутгийн төсвийн болон төслийн хөрөнгөөр 1 сургуулийн хичээлийн байр, 2 сургуулийн дотуур байрт их засвар хийж, 2 сумданд 10 ортой хүн эмнэлэгийн барилга барьж ашиглалтанд орууллаа. ЭМХ-3 төслийн хөрөнгөөр 2 сумын хүн эмнэлэг, АНЭ-ийн барилгын их засварын ажлууд хийгдэж дуусаад байна. Үүний зэрэгцээ улсын төсвийн хөрөнгөөр Наран сумын эмнэлэгт халаалтын систем тавилаа.

Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг НАА-2 төслийн хөрөнгөөр өргөтгөж засварласны дээр Түмэнцогт сумын бохир усны нэгдсэн системийг улсын төсвийн 200.0 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр шинэчлэн засварлаж, биологийн аргаар цэвэрлэх технологийг суурилуулан ажиллуулж байна.

Хур тунадасыг нэмэгдүүлж бэлчээрийн ургацыг сайжруулах хүрээнд үүлэнд зориудаар нөлөөлөх ажиллагааг 5, 6, 8 дугаар саруудад хээрийн экспидицээр хийлгэснээр хур тундасны хэмжээ олон жилийн дунджаас 27-33 хувиар нэмэгдэж бэлчээрийн ургац 19.2-53.8 хувиар сайжирсан байна.

Салхины эвдрэлээс хамгаалах зорилгоор 9000 гаруй мод, бут сөөг суулгаж 3 га талбайд чацаргана тариалаад байна.

Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах журмын дагуу 251.7 мя га газрыг сумын хамгаалалтанд авснаар аймгийн нийт нутгийн 7.2 хувь нь улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хамрагдаж байна.

Аялал жуулчлал нь тус аймагт шинэ тутам хөгжиж байгаа салбарын нэг учир хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Бичигт боомт-Хөндлөн хайлааст-Эрдэнэцагаан сум-Талын агуй-Хөргийн хөндийн хүн чулуу-Баянцагаан жуулчны бааз-Дарьганга сум-Ганга нуур-Гангын цагаан овоо-Шилийн богд уул-Бичигт боомт гэсэн маршрутаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Зүүн үзэмчин хошууны 100 орчим жуулчдыг хүлээн авч 5 удаагийн аялалыг БОАЖГазараас зохион байгуулсан.

Улсын төсвийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр орон нутгийн ойжуулалтыг Баруун Урт сумын нутаг дэвсгэрт нийт 100 га-д хайлаас, гүйлсний 30 000 ширхэг тарьц, суулгацаар хийсэн нь 75%-ийн ургалттай байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг аялал жуулчлалын салбарт татах, томоохон цогцолбор барьж байгуулах үүднээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр “Тусгай хамгаалалттай газруудад аялал жуулчлалын зориулалтаар газар олгож Эрдэнэцагаан сумын нутагт хоёр талын хөрөнгө оруулалттай аялал жуулчлалын цогцолбор баригдаж байна.

### I.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг явц, биелэлтэд аймгийн засаг даргын тамгын газрын бодлогын хэлтсүүд хяналт тавин ажиллаж, холбогдох агентлаг, албадаас тайлан мэдээнүүдийг авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж ирлээ.

2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 73 хөтөлбөрийн биелэлтийг тооцож гаргаснаас тухайн онд биелэлт нь тооцогдох 70 хөтөлбөрүүдээс 100 хувийн биелэлттэй 14 хөтөлбөр, 90 ба түүнээс дээш хувийн биелэлттэй 24 хөтөлбөр, 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй 8 хөтөлбөр байна.

Тухайн жилд хэрэгжих хөтөлбөрүүдийн биелэлт нийт дүнгээрээ 81,3 хувьтай гарав.

Дээрхи хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцохдоо 178 заалтад үнэлгээ өгсний 121 заалт 90-100 хувь, 39 заалт 51-89 хувь, 18 заалт 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй байна.

Үндэсний хөтөлбөр хэрэгжснээс хойш хийсэн ажлын биелэлтийг тооцож үзэхэд 100 хувийн биелэлттэй 6 хөтөлбөр, 90 ба түүнээс дээш хувийн биелэлттэй 13 хөтөлбөр, 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй 16 хөтөлбөр байна.

Хөтөлбөр хэрэгжснээс хойш нийт хөтөлбөрүүдийн биелэлт 70,1 хувьтай гарав.

Эдгээр хөтөлбөрүүд /хэрэгжснээс хойшхи/-ийн хэрэгжилтийг тооцохдоо 170 заалтад үнэлгээ өгсний 60 заалт 90-100 хувь, 84 заалт 51-89 хувь, 26 заалт 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй байна.

Үндэсний хөтөлбөрүүдээс “Иод дутлын эмгэгтэй тэмцэх”, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Биологийн төрөл зүйлийг хамгаалах”, “Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих”, “Албан ёсны статистикийг хөгжүүлэх” зэрэг хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна.

Орон нутгийн онцлог, мэргэжилтэй боловсон хүчин, орчин үеийн багаж төхөөрөмжөөр хангагдаж чадаагүй зэргээс шалтгаалан хэрэгжилтийн явц удаашралтай байгаа хөтөлбөрүүд гэвэл:

“Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий биелгээ”, “Түүх соёл, үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах”, “Агаарыг хамгаалах”, “Озоны үе давхаргыг хамгаалах”, Чанарын болон байгаль орчны удирдлагыг дэмжих”, “Удаан задардаг органик бохирдуулагч” хөтөлбөрүүд орж байна.

Хөтөлбөрүүдийн биелэлтийг гаргасан байдал, хэрэгжилтийн хувьтай танилцаад дараахь дүгнэлтийг хийв.

1. Бодлогын хэлтсүүд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтантай үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт, түүний хэрэгжилтийн явцыг шаардлагын хэмжээнд хүртэл тооцож ажиллахгүй, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр тэр бүр хангахгүй байх,

2. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ямар нэг хөрөнгө төлөвлөгдөөгүй, жил жилийн төсвийн төсөл тушаах, хамгаалах үеэр хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд тусгагдсан хөрөнгийг сангийн яам шууд хасч тооцдог нь бэрхшээл учруулж байна.

3. Энэ байдлаас болж хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажил тасрах буюу хэрэгжилт нь удааширч цаг алдаж байна.

#### Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ

##### 2.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн

##### чиглэлийн биелэлтийн талаар

Тус үндсэн чиглэлээс аймагтай холбогдсон зорилтуудыг бүртгэл хяналтандаа авч аймаг, сумын Засаг даргын Тамгын газраас зохиох жил, улирлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж биелэлтийн явцад байнгын хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өөрийн үйлдвэрлэлээр дотоод хэрэгцээнийхээ тодорхой хэсгийг хангах зорилт тавьж төмс, хүнсний ногоо тариалах, мал аж ахуйн гаралтай сүү, мах ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар хүнсний хэрэгцээг нэмэгдүүлж илүүдэл бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах үүднээс “Сүхбаатар хөгжил 2009” зах зээлийн өдөрлөгийг зохион байгуулж бүх сумд болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүд, ӨМӨЗО-ны Зүүн үзэмчин хошуу, Архангай, Хэнтий, Дорнод аймгийг оролцууллаа. Энэ арга хэмжээнд нийт 190 аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгчид, малчны бүлэг оролцож, 84,4 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сүүн бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах зорилгоор 2009 онд сүүний чиглэлийн үнээний ферм байгуулахаар төсөл бичсэн 10 аж ахуйн нэгж, иргэн болон сүү боловсруулах үйлдвэр байгуулах 1 иргэнийг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээлд хамруулан тэдэнд 133,3 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар “2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г баталж, аймгийн хэмжээнд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газрын байршил,

хэмжээ, зориулалтыг тогтоож өглөө. Энэ үндсэн дээр 2009 онд аймгийн хэмжээнд 1212 иргэн өрхөд 103,4 га газар өмчлүүлж газрын тухай хууль, газрын дуудлага худалдаа явуулах журмын дагуу Баруун-Урт сумын инженерийн шугам сүлжээ бүхий 1500м<sup>2</sup> хэмжээтэй газар дээр нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулав. Одоо аймгийн хэмжээнд нийт 427,8 га газар өмчлөлд, 124,2 га газар иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшилд байна.

Аймгийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг цөлжилтөнд орж ашиглах боломж хомстсонтой холбогдуулж “Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр” боловсруулж ИТХ-аар батлуулан мөрдөж байна. Энэ хүрээнд 2009 онд нийт 18 булгийн эхийг хашаажуулан, 6000 гаруй мод, суулгацыг тарьж ургуулаад байна. Цөлжилт үүссэн 17,4 мянган га нутаг бэлчээрийг чөлөөлж ус ургамлын сэргэлт бий болж хэвийн хэмжээнд ортол 3-аас доошгүй жил айл, мал нутагшуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авлаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дарьганга сум элсний нүүлтээс хамгаалахад зориулж 3500 ширхэг мод, суулгац тарьсны дээр 2 га газарт дэрс шилжүүлэн суулгав. Мөн Онгон сум 1 га газарт 1200 ширхэг чацарганы суулгац тарьж ургуулав.

Цөлжилт үүссэн зарим нутаг бэлчээрийг чөлөөлсөнтэй холбогдуулан усгүй бэлчээрийг усжуулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 24 худаг, сум орон нутаг өөрсдийн хөрөнгө хүчээр 88 гар худгийг шинээр гаргав. Мөн Онгон сумын Хавиргын булгийн 18 га газрын хуучин услалтын системийг сэргээн засварлах ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж, ашиглалтанд хүлээн авснаар 120 мянган га газар усжуулагдаж уул бэлчээрийг цаашид ашиглах боломж бүрдлээ.

ШУТИС-ийн Сүхбаатар аймаг дахь Технологийн сургууль нь дотроо Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй бөгөөд зах зээлд нэн шаардлагатай 12 мэргэжлээр сургалт явуулж 3 дахь удаагийнхаа төгсөлтийг 2009 онд хийж 90 гаруй мэргэжлийн ажилтныг улс ардын аж ахуйд нийлүүлсний 80 гаруй хувь нь ажлын байртай болжээ.

ХБНГУЛсын Нюрнберг хотын “Зах хязгааргүй шүдний эмч нар” байгууллагаас аймгийн Нэгдсэн эмнэлэг, Онгон сумын сум дундын эмнэлэгт хүүхдийн шүдний кабинет байгуулан шүдний эмнэлгийн зориулалттай иж бүрэн зөөврийн аппарат суурилуулсны дээр хөдөөгийн эмнэлгүүдийг ажиллах боловсон хүчин, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад 90 шахам сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас гарсан 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тусгай удирдамжаар сар тутам нийтийг хамарсан

арга хэмжээ зохиож 5600 орчим хүн хамруулсны дээр аймгийн биеийн тамир спортын байгууллага, сургуулиудын биеийн тамирын заалны материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч байна.

Аймгийн спорт цогцолборын барилгын ажлыг 2010 онд эхлүүлэхээр шийдвэрлэгдээд байна. “Нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулахтай холбогдуулан түүнд тусгуулах саналаа боловсруулж холбогдох газруудад хүргүүлээ.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд аймгийн төр захиргааны байгууллага хөрөнгө, хүч анхаарлаа төвлөрүүлэн ажилласнаар дээрх зорилтын биелэлт 88,9 хувьтай байна. Тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд санхүүгийн хангалттай нөөцгүйгээс зарим бэрхшээл учирсны дээр цөлжилтийг бууруулах, мод бут сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжууд бий болгох, ялангуяа төв суурин газрыг ногооруулах зорилгоор өмнөд хөршөөс манай орны нөхцөлд тохирсон модны тарьц, үрслэгийг хямд үнээр авах талаар яриа хэлцэл хийж уул асуудлыг Засгийн газарт санал болгон тавьсан боловч энэ хэр шийдвэрлэгдээгүй байна.

## 2.2.Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160-р тогтоолын дагуу “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-д заасны дагуу хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцыг улирал бүрээр тооцож ЗГХЭГ, нийтэд мэдээлж ажиллалаа.

2009 онд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хангуулахын тулд аймгийн Засаг даргын 89-тоот захирамжийг гаргаж сум, агентлагийн түвшинд мөрдүүлж, хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тасарсан болон хэрэгжилт удааширч байгаа заалтуудын биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласнаар Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 85.3 хувийн биелэлттэй байна.Тайлант хугацаанд УИХ-ын 3-н тогтоол, Засгийн газрын 89-тогтоол, Засгийн газрын хуралдааны 6- тэмдэглэл, ҮАБЗ-ийн 1 зөвлөмж нийт 99 шийдвэрийн 115 зүйл заалтыг хяналтандаа авч ажилласнаас 56-заалт буюу 48.6 хувь нь биелж, 59 заалт буюу 51.3 хувь нь хэрэгжих шатандаа байна. Ийнхүү хууль, тогтоомжууд хяналтанд авсан тогтоол шийдвэрүүдийг холбогдох хэлтэс, ажилтан бүрт хариуцуулж биелэлт үр дүнг тооцуулах ажлыг улирал тутам хийж үнэлж дүгнэж байна.

Гэвч хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүй байдал, ялангуяа хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардал төсөвт суудаггүйгээс шалтгаалан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц удааширч байна. Жил бүрийн төсвийн төсөлд тодорхой хэмжээний хөрөнгийг тусгадаг ч Сангийн яаман дээр хасагддаг учраас ямар ч хөрөнгийн эх үүсвэргүй болдог. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахад холбогдох салбарын яам, газрууд аймаг орон нутагтай хамтарч ажиллах, хамтын уялдаагаа сайжруулах шаардлага ч байна. Үндэсний хөтөлбөр, засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн хувьд хязгаарлагдмал байх нь орон нутгийн түвшинд гарч буй гол бэрхшээл болж байна.

Хойшид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээтэй холбогдуулан төлөвлөгдсөн ажлыг хэрэгжүүлэх үүднээс хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, холбогдох газар, байгууллагуудтай хамтран ажиллахад анхаарал хүчээ төвлөрүүлэн ажиллаж байна.

### 2.3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлт

Засаглалын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан батламжийн хэрэгжилтийг аймгийн ажлын нэгдсэн дүнгээр авч үзэж хяналт шинжилгээ хийж зорилт нэг бүрийн биелэлтийг тооцоход 2009 оны түвшинд 100 хувийн биелэлттэй гарлаа.

Энэ нь аймгийн Засаг даргаас орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, хүн амынхаа тав тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн бодлогын чанартай арга хэмжээ зөв зүйтэй байсан төдийгүй зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ олон нийтийн сэтгэлд нийцсэн бодитой ажил болсныг нотолж байна гэж үзлээ.

Батламжийн биелэлтийн дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

### 2.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь аймгийн ИТХурлаар хэлэлцэгдэж батлагдсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөр, ард иргэдийн санал санаачлагад үндэслэгдсэн аймаг орон нутгийг хөгжүүлэх, хүн ардынхаа аятай тухтай амьдралын баталгааг хангахад чиглэгдсэн

үндсэн зургаан бүлгийн хүрээнд нийгэм, эдийн засгийн салбар бүрээр 15 дэд бүлэгт 192 зорилтыг багтаасан бодлогын шинж чанартай томоохон баримт бичиг болсон бөгөөд 2009 он нь үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний жил байлаа.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний жилийн хүрээнд дараахь зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтуудыг олон нийт, төрийн бүх шатны байгууллага, тэнд ажиллагсадад ил тод, нээлттэй байлгах үүднээс хөтөлбөрийг тусгай товхимол болгон 300 ширхэгийг хэвлүүлэн хүргэж сурталчиллаа.

- Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 192 зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 500 гаруй зүйл заалттайгаар тухайн ажлыг гүйцэтгэх дараалал, хугацаа, хариуцах эзэн, шаардагдах хөрөнгө төсөвтэйгөөр боловсруулж батлуулан мөрдөж ажиллаж байна.

- Үйл ажиллагааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх нийт сум аймгийн ЗДТГ-ын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агенлаг албадын удирдлагуудын семинар сургалтыг оны эхэнд зохион байгуулж хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх зарчим, арга зам, хүрэх үр дүнгийн талаар нэгдсэн ойлголтонд хүрч ажлаа эхэлсэн болно.

- Аймгийн Засаг дарга орон нутгийн телевизээр “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ард иргэдийн оролцоо” сэдвээр шууд ярилцлага хийж асуултанд хариулж тэдэнтэй санал бодлоо солилцож энэ ярилцлагаа товхимол болгон хэвлүүлж хөдөө сумдын иргэдэд хүргүүж сурталчиллаа.

- Засаг дарга холбогдох мэргэжилтнүүдийн хамт 2009 оны эхний улиралд аймгийнхаа бүх сумаар явж иргэд хөдөлмөрчидтэй уулзалт ярилцлага зохион байгуулж 4 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн агуулга, чиглэлийг танилцуулж, санал бодлыг нь сонсон хойшид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон болно.

Дээрх ажлуудын үр дүнд Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн нийт ард иргэдэд хүрч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд иргэдээс гаргасан онцгой саналыг нэмж тусган ажилласнаар төрийн болон төрийн бус байгууллагуудын цаашдын үйл ажиллагааны чиглэл тодорхой болж хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт бага, орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй, төсөв санхүүгийн хувьд хүндхэн жил болж өнгөрлөө. Энэ нөхцөл байдалд бид үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаа нарийвчлан эрэмбэлж хөрөнгө мөнгөний боломжтой болон хөрөнгө шаардагдахгүй ажлуудаа хийж эхлэх, хөрөнгө дутагдалтайгаас хэрэгжих боломжгүй ажлуудын бэлтгэл ажлыг хангах зохион байгууллалтыг хийснээр бүхий л ажлаа эхлүүлэх чиглэл барьж ажилласан болно.

Ийнхүү Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 2009 онд тавигдсан зорилтын хүрээнд 101,8, 4 жилийн зорилттой харьцуулан авч үзвэл 25.4 хувьтай гүйцэтгэгдсэн байна.

Хөтөлбөрт тусгагдсан ажлууд хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдан хийгдэж үр дүн нь тодорхойлогдож хавсралт тайлангаар хүргэгдэж байгаа учир бүтээн байгуулалтын шинж чанартай томоохон ажлуудаас заримыг нь дурьдвал:

- Төсөв хөрөнгийн дутагдалтай нөхцөлд орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, татварын бүрэн хураалтыг эрчимжүүлэх чиглэлээр олон ажлуудыг зохион байгуулсны дээр аймгийн ИТХ-аар хилийн “Бичигт” боомтоор зорчих автомашинаас “Байгальтай харьцах эрхийн хураамж” – ийг авахаар шийдвэр гаргуулж гүйцэтгэлийг зохион байгуулж ажилласнаар 146.0 сая төгрөг, хилийн боомт дээр татварын улсын байцаагчийг орон тоогоор ажиллуулснаар 150.0 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт нэмэгдүүлэн оруулж энэ эх үүсвэрийг орон нутгийн хөрөнгө оруулалтанд зарцууллаа.

- Улсын болон орон нутгийн төсвийн 264.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт суманд ус цэвэршүүлэх төхөөрөмжийг барьж байгуулснаар иргэд эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан цэвэр усыг хэрэглэх нөхцөл бүрдсэн бөгөөд энэ нь ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахын төлөө томоохон хөрөнгө оруулалт хийгдсэн, үр дүнтэй ажил боллоо.

- Орон нутгийн замын сангийн хөрөнгө болон Баруун-Урт суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд байгууллагуудын хандив тусламжаар нийт 159.0 сая төгрөгийн хөрөнгөөр 324 метр урттай, 5 метрийн өргөнтэй хатуу хучилттай автомашины зам болон 4020 м.кв явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий “Худалдааны гудамж” –ийг барьж байгуулснаар хотын өнгө үзэмж сайжирч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн, ард иргэдийн аятай тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн ач холбогдол бүхий ажил боллоо. Мөн аймгийн төвд 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 70 машины

зогсоолыг байгуулсан, 50.0 сая төгрөгийн өртгөөр баруун районыг хотын төвтэй холбосон болон хотын дотор 1 км явган хүний зам тавьсан нь хотын тохижилтонд өнгө үзэмж нэмсэн төдийгүй жолооч, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангаж, тэдний таашаалд нийсэн цогц ажил болсон юм.

- Бага , дунд орлоготой өрхөд зориулан нэгдсэн халаалттай, цэвэр бохир усны шугамд холбогдсон өртөг багатай орон сууцны барилга барихаар зураг төсвийг боловсруулан ажилласан бөгөөд эхний ээлжинд 45-ыг нь ашиглалтанд хүлээн авахад бэлэн болоод байна.

- Хотын өнгө үзэмж, оршин суугчдын амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор 100 өрхийн жишиг хороолол байгуулах санаачлага хөдөлгөөн өрнүүлж өмчлөлийн газрыг нь олгуулж, ус, цахилгааны асуудлыг төвлөрсөн хангамжаас шийдэж, нэг загварын шинэ хашаа барих ажлын 50 хувийг гүйцэтгэж хүлээлгэн өглөө.

- Олон наст гоёлын модыг шилжүүлэн суулгаж нутагшуулах ажлыг эхлүүлж, 300 гаруй модны суулгацаар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

- Тухайн аймгийн хутаг дэвсгэр дээр ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшдэг аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудтай ажил төрлийн уулзалт зохион байгуулж, гэрээ байгуулан хамтарч ажилласнаар хууль тогтоомжоор төлдөг татвар хураамжаас гадуур хөрөнгө төвлөрүүлж ард иргэдийн цахилгааны болон нүүрс түлээний үнийн хөнгөлөлт, орон нутгийн хөгжлийн зарим хөрөнгө оруулалтанд батлагдсан журмын дагуу зарцуулж ажиллалаа.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь нийтлэг хүндрэл бэрхшээлүүд учирч байна . Үүнд:

Төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, томоохон хөрөнгө оруулалт шаардагдсан ажлуудыг эхлүүлэх боломжгүй байна. Нөгөө талаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломжуудыг судлан зохих шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж ажилласнаар орон нутгийн орлого нэмэгддэг, цаашид нэмэгдүүлэх боломж байгаа хэдий ч өнөөгийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, төсвийг хянаж, баталж буй арга аргачлалын хувьд дотоод эх үүсвэрийг дайчилж олсон орлогыг аймаг орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, ард иргэдийн амьдралын сайн сайхны төлөө зарцуулах боломж олгогддоггүй. Учир нь нэмэгдүүлж олсон эх үүсвэрээр бодитой биш төлөвлөгдсөн орлогын дутагдлыг нөхдөг, мөн дараа оны

төсөвт орлогыг тэр хэмжээгээр нэмж орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлээд баталчихдаг. Тухайлбал, манай аймгийн Бичигтийн хилийн боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай боомт учир хил орчмын байгалийг хамгаалах, боомтын захиргаатай болох, эмнэлэг, цагдаагийн хэсгийг байгуулж ажиллуулах зэрэг олон ажлыг зохион байгуулах шаардлага бий болдог. Иймээс 2009 онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр “Байгальтай харьцах эрхийн хураамж”-ийг авч, төсөвт 146.0 сая төгрөгийн орлогыг оруулсан, гэтэл 2010 оны төсөвт дээрхи орлогыг 200.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж тооцсон боловч төсвийн зарлагыг тухайн зориулалтаар нэмж тооцохгүйгээр улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлж баталсан байх жишээтэй. Иймд төсвийг хянаж батлахдаа орон нутгийн санал санаачлагыг дэмжиж, эрх хэмжээг нь нэмэгдүүлж, онцлог байдлыг нь харгалзан үзэх шаардлагатай байгаа юм.

Орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, салбарын Яамдууд, орон нутгийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо зарим зүйл дээр хангалтгүй байдгаас улсын төсвийн болон сайд нарын багцаас хийгдэж байгаа хөрөнгө оруулалт нь орон нутгийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагад нийцээгүй, эсвэл тухайн ажлыг гүйцэтгэхэд хөрөнгийн хэмжээ нь хүрэлцэхгүй байх зэргээр үр өгөөжгүй хөрөнгө оруулалтууд хийгддэг дутагдал байна.

Мөн төсвийн бодлого, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах хууль тогтоомж, заавар журмууд нь уян хатан бишээс улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн онцлог, цаг үеийн байдалд тохируулан хэвийн ханган ажиллуулах нөхцөл боломж бүрддэггүй зэрэг цаашид зайлшгүй анхаарч хэрэгжүүлэх ажлууд байна.

Цаашид үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад дараахь зүйлүүдэд анхаарах шаардлагатай байгаа юм.

- Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын болон урсгал үйл ажиллагааны зураг, төсөв, шаардагдагдах хөрөнгийн хэмжээг нарийвчлан хийж улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгохын зэрэгцээ хөрөнгө дутагдах тохиолдолд түүнийг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах.

-Агентлаг албадууд, ажил хариуцсан хүмүүсийн идэвхи санаачлага, ажлын хариуцлагыг сайжруулахын зэрэгцээ үйл ажиллагааны гүйцэтгэлийн зохион байгуулалт, хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэдийн оролцоо, хяналтыг хангаж ажиллах.

Гурав.Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

### 3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

Тус аймгийн Засаг дарга нь тайлангийн хугацаанд 10 цогц бодлогын хүрээнд Засгийн газрын тэргүүн болон шадар сайд, засгийн газрын бусад гишүүн 8 сайд, хоёр газартай нийт 257 төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэх 12 гэрээ байгуулан үр дүнг тооцон ажиллалаа.

Гэрээнд заагдсан бүтээгдэхүүн нэг бүрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын засаг дарга, хэлтэс, агентлаг, албадын дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээнд тусган тогтмол хянаж, улирал тутам холбогдох хэлтэс, агентлаг, албадаас биелэлтийг авч хяналт шинжилгээ хийж үр дүнг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллалаа.

Энэхүү гэрээг хэрэгжүүлэх үүднээс гэрээ байгуулагч талуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай байнгын холбоотой ажиллаж төсөв хөрөнгө, удирдлага, зохион байгуулалтын болон бусад ажил дээр дэмжлэг туслалцаа авах замаар хамтран ажиллах талаар түлхүү анхаарсан болно.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн дагуу сар бүрийн санхүүжилтийн тайлан, улирал бүрийн эцэст бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний тайланг гарган гэрээ байгуулагч талуудад хүргүүлэн гэрээний биелэлт, явц байдлын талаар харилцан мэдээлэл солилцох, зарим асуудлыг тодотгох арга хэмжээ авч байгаа нь үр дүнгээ өглөө.

Гэрээний биелэлтэнд хяналт шинжилгээ хийж дүгнэхэд хууль зүй, нийгмийн хамгаалал хөдөлмөр, авлигатай тэмцэх, иргэний нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухаан, батлан хамгаалах, стандартчлал хэмжилзүй, мэргэжлийн хяналтын чиглэлээр байгуулагдсан гэрээний биелэлт 93,8-99,0 хувийн биелэлттэй байгаа нь нийт гэрээний 66,7 хувь нь болж байна. Харин нь хүүхдийн эрхийг хамгаалах, онцгой байдал, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр байгуулагдсан гэрээний биелэлт 76,5-86,5 хувийн биелэлттэй дүгнэгдлээ. Гэрээний биелэлтийг нийт дүнгээр нь авч үзвэл 90,5 хувийн биелэлттэй байна.

Гэрээнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх явцад төсвийн тодотгол хийгдэж төлөвлөгдсөн асуудал хасагдах, төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлаар зарим нэг бэрхшээл учирч хэрэгжилтийн явц удаашрах, тасрах явдал байлаа.

Цаашид төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг даргатай байгуулах гэрээнд аймаг орон нутгийн саналыг тусгах талаар анхаарах зайлшгүй шаардлага байна.

### 3.2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан

#### үр дүнгийн гэрээний биелэлт

Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг 2009 оны 6-р сарын 10 ны өдрөөс эхлэн 2009 оны 12-р сарын 29 хүртэл буюу хагас жилийн ажлын тайланг үндэслэн 92 хувь буюу “А” дүгнэлээ.

2009 он бол дэлхий дахиныг хамарсан санхүүгийн хямралтай жил байсан ч АЗДТГ өмнөө тавьсан зорилтоо биелүүлж ажилласан гэж үзэж болно.

Аймгийн ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдаанаас аймгийн Засан даргын 2009 оны үйл ажиллагааг хуралд оролцсон төлөөлөгчдийн 96 хувийн саналаар “Хангалттай” гэж үзсэн ба үүнд ЗДТГ-ын оролцоо өндөр байсан. Мөн аймаг сумын ЗДТГ-ын ажлыг шалгасан Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр 91 оноо авч сайн гэж дүгнэгдсэн тэр дундаа Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтаар 98 оноо авч маш сайн гэсэн үнэлгээ авсан зэрэг нь гэрээний нэлээдгүй заалтыг сайн гэж дүгнэхэд хүргэжээ.

Сумд, агентлагуудын ажлын явцад ХШҮ хийсэн, ХАА, газар, бүртгэлийн болон байгаль орчны чиглэлээр хийсэн ажлууд үр дүнгээ өгсөн ба Засаг даргын дэргэдэх агентлаг албадууд ажлаараа улсын хэмжээнд дээгүүр байр эзэлсэн юм.

Мөн хямарлын үед хөрөнгө төвлөрүүлэх, ариг гамтай зарцуулах чиглэлээр санаачлагтай ажиллаж аймгийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бөгөөд орон нутагт бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын томоохон ажлуудыг санаачилж хийсэн байна.

Цаашид агентлаг албадын ажлыг хооронд нь холбох, сумдын ажилтай уялдуулах тал дээр санаачлага гаргаж төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

#### 4.1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албад өөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд юуны өмнө тус тусын байгууллагынхаа стратегийн зорилго, зорилт, чиглэл, боловсруулж, ажилтан бүрийн хариуцсан ажил үүргийн хуваарь, утас, өрөөний дугаар зэрэг хүмүүс хэн нэгний дэмжлэггүйгээр эхний ээлжинд мэдэж болох асуудлуудыг хүн үзэж танилцах бололцоотой газар ил тодоор байрлуулж суртачллах, иргэд олон нийтэд ажлыхаа цуглаан, уулзалт, ярилцлага хэлбэрээр болон мэдээллийн хэрэгслээр дамжуулан суртачилж хүргэх аргыг өргөн хэрэглэж тэдний санаа бодлыг сонсох, судалгаа явуулж хүсэл зоргийг нь судалж мэдэхийг чухалчлан үзэж ирлээ.

Түүнчлэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигсөд, ажил, албандаа хариуцлагагүй хандагсадтай дор бүр нь хариуцлага тооцож шаардлагатай гэж үзвэл нийтэд мэдээлж хариуцлагын түвшинг өндөржүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, аль болох иргэдэд ойр дөт байж үйлчлэх, үйлчилгээг хөнгөн шуурхай чирэгдэлгүй болгоход анхаарлаа хандуулж ажиллаж байна. Үүний зэрэгцээ аймгийн төр захиргааны байгууллагаас гаргах шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох байгууллага, албан тушаалтны саналыг авахын зэрэгцээ иргэний нийгмийн байгууллага, тэдний төлөөллийг оролцуулдаг болсон нь үр дүнгээ өгч байна.

Байгууллага, албан тушаалтанд ирсэн аливаа өргөдөл, гомдлыг судалж барагдуулах ажлыг тухай бүрд нь хэрэгжүүлж хариуг эзэнд нь мэдэгддэг, иргэдэд тайлагнадаг журам тогтоож хэвшүүллээ.

#### 4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Энэ хүрээнд төрийн албан хаагчдыг шилж сонгож зөв байршуулах, төрийн албанд ажиллагсадыг сургаж, бэлтгэх, давтан сургаж мэргэшүүлэх ажлыг тусгай бодлого, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж байна. “Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”-ийг боловсруулж уул хөтөлбөрийнхөө зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, удирдлагын академи зэрэг удирдах дээд байгууллага, бүсийн аймгуудтайгаа хамтран ажиллаж зохих үр дүнд хүрч байна.

Төрийн албан хаагчдыг орчин үеийн мэдээллийн хэрэгсэл, цахим төхөөрөмжөөр хангах түүн дээр ажиллах чадвар эзэмшүүлэхэд ч онцгой анхаарч ажиллаж байна.

Хүний нөөцийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхдөө зөвхөн удирдлагын зүгээс ханддаг байсан хандлагыг өөрчилж ажилтан бүрийг өөрсдийг нь оролцуулдаг болсон нь ажлын үр дүн үнэлгээний бодит байдалд чухал нөлөө үзүүлдэг боллоо.

Төрийн албан хаагчдын ажлын үр дүнгээр урамшуулах, хариуцлагыг авч үзэж байгаа нь ажилд хандах хандлагыг дээшлүүлсэн, хариуцлагын тогтолцоог сайжруулах нэг арга болж байна.

Төрийн албанд орж ажиллагсадыг тусгай шалгуураар шалгаж, болзол нөхцөлийг хангасан хүнийг авах ажиллагаа ч олон нийтэд ил явагддаг болсноор элдэв зөрчил дутагдал гарах явдлыг хаах болсон юм.

#### 4.3.Төсөв, санхүүгийн ил тод байдал

Төсвийн ил тод байдлыг хангах ажлыг түүнийг боловсруулах үе шатнаас эхэлж хэрэгжиж дуусах хүртэл явагдаж байгаагаараа онцлог байна.

Нөгөө талаар элдэв хардлага, буруу хандлага дагуулдаг тендер зарлах, төсөл, хөтөлбөр шалгаруулах, зээл тусламж олгох зэрэг хөрөнгө мөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх комисс, зөвлөл, хороо, ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж, Аудит, Мэргэжлийн хяналтын газар зэрэг хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулдаг нь үр дүнгээ өгдөг боллоо.

Аймаг болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд жил бүр аудит хийлгэж түүний дүнг олон нийтэд мэдээлж, аймгийн ВЭБ сайт, боломжгүй газар самбар мэдээллийн хэрэгслээр сурталчилдаг боллоо.

#### 4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

Тендер шалгаруулах үйл ажиллагааны бэлтгэлийг чанартай хангах, нийтэд мэдээлж ил тодоор сурталчлах зорилгоор цахим хуудас, хэвлэлийг өргөн ашиглаж байна.

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг олон нийтэд мэдээлдэг журам тогтлоо.

Ийнхүү нийтийн санал бодлыг сонсч, үйл ажиллагаагаа илээр явуулснаар 2009 оны түвшинд худалдан авах ажил үйлчилгээний талаар иргэд, байгууллагаас ямар нэг гомдол гараагүй болно.

Ийнхүү байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүхэлд нь тооцож үзвэл 99,1 хувийн гүйцэтгэлтэй, 4,95 оноотой байна.

#### Тав. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

##### 5.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэлийг

-Эдийн засгийн

-Нийгмийн

-Хөгжлийн

гэсэн гурван бүлэгт 56 үзүүлэлт, зорилттойгоор боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж түүний хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг дарга, Тамгын газар санхүүгийн нөөцийг бүрэн дайчилж оновчтой хуваарилахын зэрэгцээ ажиллах хүчнийг зөв байршуулж төрийн болон төрийн бус байгууллага, нийт иргэдийн хүчийг чиглүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсний дүнд

-Эдийн засгийн хүрээнд дэвшүүлсэн 21 зорилтоос 16-г зуу ба түүнээс дээш, 4-ийг 80,7-96,8 хувиар биелүүлж 1 зорилт төлөвлөгдсөн арга хэмжээгүй учир дүгнэгдсэнгүй.

-Нийгмийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн 21 зорилтоос 6-г зуу үүнээс дээш, 5-ыг 66,0-99,0 хувиар,

-Хөгжлийн бодлогын хүрээнд тавьсан 14 зорилтоос 13 нь зуу, зуугаас дээш, 1 зорилт нь 2009 онд төлөвлөгдөөгүй учир тооцогдоогүй болно.

Нийт дүнгээрээ 95,8 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Тайлант онд тавигдсан зорилтыг хангахад юуны урьд аймгийн төр, захиргааны байгууллага, бодлого зорилтоо олон нийтэд хүргэж суртачлах арга хэмжээ авсан нь нийтийн хүчийг нэг зүгт чиглүүлэхэд чухал алхам болсон байна. Нөгөө талаар тавьсан зорилттойгоо холбогдуулан төрийн болоод төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн идэвх санаачлагыг өрнүүлэх, удирдах дээд шатны байгууллагаас дэмжлэг авч хамтарч ажиллах талаар санаачилга гаргасан нь үр дүнтэй болжээ.

Ийнхүү 2009 онд “Үйлдвэрлэлийн хүрээг өргөтгөж хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн хүн амынхаа ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” талаар тавьсан зорилт үндсэндээ амжилттай хэрэгжсэн байна гэж үзлээ.

## 5.2.Хэрэглэгчдийн судалгааны үр дүнгийн талаар:

Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн ахуй амьдрал, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилготойгоор иргэдийн дунд санал асуулгыг 2009 онд 2-удаагийн давтамжтай 13 суманд зохион явуулж 844 иргэн судалгаанд хамрагдлаа. Энэ нь аймгийн насанд хүрсэн хүн амын 3- хувийг эзэлж байна.

Судалгааны ажлыг зохион явуулахдаа “Иргэний нийгмийн сүлжээ” төрийн бус байгууллагыг судалгаанд бие даан оролцуулж санал асуулгыг авахуулав.

Судалгаанд сумдын сургууль, цэцэрлэг, соёлын төв, хүн эмнэлэг зэрэг төсөвт, ахмадын хороо, эмэгтэйчүүдийн холбоо, залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг төрийн бус байгууллага, бизнэс эрхлэгчид, малчид, ажилгүй иргэд зэрэг зорилтод бүлгүүдээс төлөөлөл оролцлоо. Ингэснээр аймгийн голлох давхаргын төлөөлөл хамрагдснаар судалгааны үнэн бодит байдлыг хангахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Судалгаанд нийт 844 хүн оролцсоны 318 нь төсөвт байгууллагаас, 155-нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээс, 144-нь малчин, 155-нь ажилгүй иргэд, 72-нь төрийн бус байгууллагаас хамрагдсан байна. Судалгааны дүнг 5-үндсэн асуултын хүрээнд дүгнэж үзэхэд 76.0-хувийн гүйцэтгэл, 3.80-оноотой байна.

Орон нутагт зохион явуулсан судалгааны дүнгээс харахад төрийн байгууллагууд иргэдэд ил, тод, хөнгөх шуурхай үйлчлэх, иргэдийн өргөдөл гомдлыг цаг хугацаанд барагдуулах, сумдын төсөвт байгууллага, Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг албадын үйл ажиллагаа тогтмолжиж байгаа нийтлэг давуу талууд байгаа боловч ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, архидалт, үнийн өсөлтийг бууруулах талаар цаашид дорвитой арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Мөн сум орон нутгийн түвшинд боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг олноор нэмэгдүүлж ажиллах нь тулгамдсан гол асуудал болоод байгааг судалгаа харуулж байгаа юм.

Дээрх байдалд дүгнэлт хийж сумдын Засаг дарга, Тамгын газар, агентлаг албадад холбогдох зөвлөмж чиглэлийг өгч ажиллаж, ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилгоор 265 ядуу өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, ядуурлаас гаргах ажил 13 суманд зохион явагдаж байгаа бөгөөд шинээр нэмэгдүүлсэн ажлын байрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн нь судалгааны үр дүнгийн мөрөөр тодорхой бодлогын арга хэмжээ авч байгаагийн илрэл мөн.

2010 оны хувьд хэрэглэгчдийн судалгааг зохион явуулах арга хэмжээний хүрээнд журамд заасны дагуу мэргэжлийн судалгааны байгууллагуудад хамтарч ажиллах санал, хүсэлтийг уламжлаад байгаа бөгөөд холбогдон гарах зардлыг орон нутгаас гаргахаар тооцож байна.

Ийнхүү Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн 2009 оны ажлыг бүхэлд нь нэгтгэн дүгнэж үзвэл :

1.Улс орны хэмжээнд төдийгүй дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын үед санхүү, төсөв хөрөнгийн бололцоотой бүхий л эх үүсвэрийг дайчлах замаар төлөвлөсөн ажлаа хэвийн хэмжээнд гүйцэтгэх үүднээс

-Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн үзлэг тооллогыг дээд зэргийн зохион байгуулалттай явуулж өөрийн аймгийн нутаг дэвсгэрт буй бүхий л авто тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулж татвар ногдуулалтыг хуулийн хүрээнд хийж 104,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх жилээс 30 шахам сая төгрөгөөр давсан юм.

-Ашигт малтмалын нөөцийн төлбөрөөс орох орлогыг буруу аргачлалаар тооцож байсныг засан залруулах талаар холбогдох байгууллагад хандсанаар 819,0 сая төгрөгийн зөрүүг авлаа.

-Бичигт олон улсын боомтоор нэвтэрч буй тээврийн хэрэгслээс байгальтай харьцсаны эрхийн хураамж авах талаар аймгийн ИТХ-ын шийдвэр гарч хэрэгжүүлснээр 140,0 сая, тус боомт дээр татварын улсын байцаагчийг орон тоогоор ажиллуулснаар 150,0 сая төгрөгийн нэмэгдэл эх үүсвэр олсон юм.

Энэ бүхний дүнд аймаг төсвийн орлогын төлөвлөгөөгөө дүнгээр нь 104,7 хувиар биелүүлж, өмнөх онд байсан өр авлагыг 70,2 хувиар бууруулан аймаг өөрөө өөрийгөө санхүүжүүлэн улсын төсөвт 706,1 сая төгрөгийг төвлөрүүлж улсын төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүллээ.

2.Аймгийнхаа хүн амын нийгмийн асуудалд жигд анхаарч 3735 өрхийн 3 сарын цахилгааны үнэнийн хөнгөлөлтөд 92,5 сая, 2850 өрхийн түлшний үнэ /өрх бүрт 5 тн нүүрс/-д 180,0 сая төгрөг, хөдөөгийн малтай 660 өрхөд малын тэжээл авахад 11880 мянган төгрөг бүгд 284,3 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсний дээр 450 өрхөд шинэ гэр олгож сууцны нөхцөлийг сайжрууллаа.

Цөөн малтай буюу огт малгүй болсон 1067 өрхийг малжуулахад 620,0 сая төгрөг зарцууллаа.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд 54 төсөлд 780,0 сая төгрөгийн зээл олгосноор 10 шахам үйлдвэр шинээр нэмэгдэж, 50 хүн шинээр ажлын байртай болсон байна.

3.Аймаг 2009 онд тавьсан зорилтынхоо хүрээнд сар бүр нэг, жилдээ 12 бүтээлч ажил хийхээр төлөвлөж

-Замын сангийн болон Баруун-Урт суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр 159,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 554 м хатуу хучилттай зам талбай байгуулж “Худалдааны гудамж”-ийг тохижууллаа.

-Аймгийн төвийн худалдаа үйлчилгээ төвлөрсөн газарт 70 машины зогсоолыг 59,0 сая төгрөгийн өртгөөр барьж байгууллаа.

-Үйлдвэрийн районыг аймгийн төвтэй холбосон явган хүний 850 м урт замыг 36,5 сая төгрөгийн өртгөөр тавьж хүний аюулгүй ажиллагааг хангав.

-Хотын үзэмж, оршин суугчдын ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор 100 өрхийн жишиг хороолол байгуулах санаачилга хөдөлгөөнийг өрнүүлж өмчлөлийн газрыг нь олгож, ус цахилгааныг төвлөрсөн хангамжаас шийдэж хашааг нэг хэв загвараар барьж хөрөнгийн тавин хувийг банкны зээлээр олгохоор шийдэж өглөө.

-Бага дунд орлоготой 150 айлын орон сууц барих хөтөлбөр боловсруулж эхний ээлжинд төвлөрсөн дулаан, цэвэр усанд холбогдсон 45 айлын сууцыг барьж ашиглалтад орууллаа.

-Аймгийн төв Баруун-Урт сумын иргэдийн ундны хэрэгцээний усыг цэвэршүүлэх төхөөрөмжийг 270 сая төгрөгийн төсөвт өртгөөр барьж ашиглалтад оруулснаар хотын хүн ам стандартын шаардлага хангасан ундны ус ашиглах боллоо.

-Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хотын хүн амын эрүүл орчинд аж төрөхөд нөлөө үзүүлэх зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО-ноос олон наст гоёлын модыг шилжүүлэн суулгаж нутагшуулах туршилтын хүрээнд 3000 модны суулгац авч тариаллаа.

-Аймгийнхаа хүн амыг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах үүднээс 10 га газарт чацарганы 1000 гаруй суулгац суулгаж хашиж хамгаалан цаашид жимс, жимсгэний аж ахуй байгуулах эхлэлийг тавилаа.

-Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын Шилийн гол аймагтай хамтарч нэг ээлжиндээ 100 жуулчин хүлээн авах хүчин чадалтай аялал жуулчлалын цогцолбор барьж байгуулах ажил эхэлж энэ оны 6-р сард хүлээн авахаар бэлтгэлийг хангаж байна.

-Аймгийнхаа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг болон ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдтэй нэг бүрчлэн уулзаж байгаль

орчны нөхөн сэргээлт, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах чиглэл, харилцан хүлээн үүрэг, орон нутагт үзүүлдэг туслалцаа дэмжлэгийг цэгцлэх зорилгоор яриа хэлцэл хийж харилцан хамтран ажиллах талаар гэрээ байгуулж ажиллаж байгаа нь нэг талаар ажлын зохион байгуулалт дээшлэх нөгөө талаар харилцан бие биеэ ойлголцох, хөрөнгө хүч төвлөрхөд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

-Хотын төвийн өнгө үзэмжинд сөрөг нөлөө үзүүлж байсан орон сууц орчмын ТҮЦ, амбар савыг цэгцлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж заагдсан талбайд шилжүүлэн байршуулж дараагийн шатны тохижилтын ажлыг хийх боломжийг бүрдүүлээ.

-1945 оны чөлөөлөх дайнд тус аймгаас оролцсон дайчдын болон зарим алдартай хүмүүсийн дурсгалыг мөнхжүүлэх зоригор Батлан хамгаалах яам, орон нутгийн соёлын байгууллагуудтайгаа хамтран хөшөө дурсгалыг бүтээж босголоо.

-Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах бусад байгууллага, газартай ажлын арга барилыг солилцуулах зорилгоор “Сүхбаатар зах зээл 2009” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 13 сум, 84 аж ахуйн нэгж иргэнийг хамруулсны дээр Архангай, Хэнтий, Дорнод аймаг, ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу оролцсон нь уул арга хэмжээг өргөн дэлгэр болголоо. Энэ арга хэмжээний үеэр 84.0 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийж, хөмүүл, танын дарш, цагаан эсгий, зөгийн бал, мал аж ахуйн тоног хэрэгсэл, орон нутагт тарьж ургуулсан төмс, хүнсний ногоо, төрөл бүрийн цагаан идээ, гэрийн тавилга, мод зэрэг 20 гаруй бүтээгдэхүүний захиалга өгөгдсөн байна. Түүнчлэн аймаг дотор үржүүлж буй өндөр ашиг шимт шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа болж ноолуурын чиглэлийн улаан ухна, илүү нугаламт үзэмчин хонь, махны хэвшлийн Түмэнцогт үхэр, хурдан удмын адууны эрэлт хэрэгцээ бусдаас илүү өндөр байлаа.

-Аймаг 15191 өрхийн 54363 хүний мэдээлийг 300 гаруй үзүүлэлтэд багтаасан хүн амын мэдээллийн цахим сан баазтай болсны дээр “Малын индексжүүлсэн даатгал” төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан 9075 малтай өрхийн 1,8 сая малын мэдээллийг багтаасан малын цахим сантай болж төрийн бодлого боловсруулах, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх зэрэг олон арга хэмжээнд ашиглаж байгаа нь ажил хөнгөвчилсөн энэ талын шаардлагатай мэдээллээ хүссэн цагтаа авч ашиглах боломжийг бүрдүүлээд байна.

Энэ бүхний дүнд аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд түүний дотор боловсрол, соёл, эрүүл мэнд, хүн амын чиглэлийн оны түвшинд тавигдсан зорилт үндсэндээ хангагдаж аймгийн хэмжээнд хүн амын шилжилт сүүлийн 2 жилд буурч шилжиж

ирэгсэд жил дараалан өсч нийт хүн ам өмнөх жилээс өссөн нь тус аймагт хүн амын ажиллаж амьдрах таатай орчин бүрдэж байгаагийн нэг үзүүлэлт болж байна.

Түүнчлэн ажилгүйдлын түвшин тодорхой шалтгааны улмаас өссөн ч ядуурлын түвшин 3.6 хувиар буурч, гэмт хэргийн гаралтыг өнгөрсөн оны түвшинд барьж, илрүүлэлтийг 95 хувьд хүргэсэн нь улсын дунджаас 30 шахам хувиар дээгүүр байна.

Аймаг 2009 онд аж үйлдвэрийн бүтээдэхүүний үйлдвэрлэлээр бүх аймаг, нийслэлийн дотор 4-т, цахилгаан эрчим хүчний хангамжаар эхний 5 аймагт багтаж байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ЖАВХААТӨГС